

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ХАНХ СУМЫН НУТАГТ ОРШИХ “АГАРТА РЕСОРТ” АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БААЗЫН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН.

/Аж ахуйн нэгжийн регистрийн дугаар № **5514231**/

Хянасан: БОУАӨЯ-ны Хүрээлэн буй орчны бодлогын хэрэгжилтийн газрын
ахлах шинжээч.....Ц.Жаргалнэмэх.

Биелэлтийг тайлагнасан: “Агарт ресорт вилла” ХХК-ийн
Гүйцэтгэх захирал Ш.Эрдэнэсүрэн.

Байгаль орчны мэргэжилтэн.....Д.Хуягбаатар.



УЛААНБААТАР 2025 ОН

АГУУЛГА

1.ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2-4
1.1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага.....	2
1.2. Төслийн байршил.....	2
1.3. Хүчин чадал.....	2
1.4. Ажиллах хүч.....	2
1.5. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг.....	2
1.6. Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал.....	2
1.7. Дэд бүтэц.....	3
1.7.1. Цахилгаан хангамж.....	4
1.7.2. Цэвэр усны хэрэглээ.....	4
2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	5-7
3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.....	7
3.1. Байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй.....	7
4. БОМТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ДАГУУ ХИЙГДСЭН АЖЛЫН ТАЙЛАН.....	8-9
Хавсралт зургууд.....	10-12
ХАВСРАЛТ МАТЕРИАЛ.....	13

1 ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

- 1.1. Хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:** “Агарта ресорт вилла” ХХК
 - Улсын бүртгэлийн дугаар: 9011305057
 - Регистрийн дугаар: 5514231
- 1.2. Төслийн байршил:** Хөвсгөл аймгийн Ханх сум, Анжигасын ам
- 1.3. Хүчин чадал:** Жил 6-р сарын 25-аас 9-р сарын 25 хүртэлх хугацаанд үйл ажиллагаа явуулдаг ба нэг ээлжинд 40-60 амрагч хүлээн авах хүчин чадалтай.
- 1.4. Ажиллах хүч:** Эрхлэгч, тогооч, үйлчлэгч, харуул, жолооч зэрэг ажил эрхэлдэг 30 ажилчинтай.
- 1.5. Барилга байгууламжийн бүрэлдэхүүн хэсэг:** Аялал жуулчлалын бааз нь дараах байгууламжуудаас бүрдэнэ.
 - Тансаг зэрэглэлийн хаус 4 ш
 - Студио хаус 10 ш
 - Люкс гэр 12 ш, хагас люкс гэр 8 ш
 - Ресторан, лоунж, задгай талбай террас.
 - Алжаал тайлах төв
 - Спорт талбай, тоглоомын өрөө
 - Ажилчдын байр, цайны газар
 - Угаалга, бие засах газар
 - Авто болон завины зогсоол зэргээс бүрдэнэ.
- 1.6. Завсрын бүтээгдэхүүн, хог хаягдал:** Аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас хатуу, шингэн хог хаягдал гарна.
Хатуу хог хаягдал: Баазын үйл ажиллагаанаас цаас, хуванцар сав, гялгар уут, хоол хүнсний хаягдал зэрэг хаягдлууд гарах бөгөөд нийт ажиллах хугацаанд 2.5 тн хатуу хог хаягдал гарахаар БОННУ-д тооцсон.
Шингэн хаягдал: Нийт ажиллах хугацаанд 360 тн усыг унд ахуйн зориулалтаар хэрэглэх бөгөөд түүний 70% буюу 250 тн цэвэршүүлсэн бохир ус буюу /саарал ус/ гарна.

“Агарта ресорт” АЖБ нь Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газрын хязгаарлалтын бүсэд 14.8 га талбайд оршино.

“Мөнх Эрин Трэвел” ХХК нь 2013 оноос Хөвсгөл аймгийн Ханх сумын нутагт байрлах Анжигансын аманд “Агарта” ресортыг байгуулсан. 2023 онд тус компанийн хувьцаа эзэмшигчийн шийдвэрээр компанийн нэрийг “Агарта ресорт вилла” болгон өөрчилсөн. Энэхүү шийдвэрийг ААН-н гэрчилгээний хамт хавсралт хэсэг оруулав.

Тус ресорт нь 2015 оны 6 дугаар сарын 30-ны өдөр эхний үйлчлүүлэгчдээ хүлээн авч, албан ёсоор үйл ажиллагаагаа эхлүүлсэн Олон улсын чанарын жишигт хүрсэн эко бааз болох эрхэм зорилгодоо хүрэхийн тулд Экотуризмын тулгуур зарчмуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж “Байгальд ээлтэй, Соёлтой үйлчилгээ, Тав тухтай орчин, Тогтвортой байдал” уриаг удиртгал болгон ажиллаж байна.



Зураг 1, 2. Жуулчдын баазын ерөнхий байдал

1.7. Дэд бүтэц

1.7.1. Цахилгаан: Нар, салхины сэргээгдэх эрчим хүч болон цахилгаан үүсгүүрээр өөрийн эрчим хүчний хэрэгцээгээ хангана. Гэр ресторан, сауны барилга, баазын экохаус болон амрагчдын гэрүүд нь бүгд наран тал руу харсан шилэн хийцтэй учир өдрийн цагт нарны илчээр халахаар тооцож төлөвлөсөн. Үүн дээр нэмээд объектүүдэд цахилгаан халаагууруудыг суурилуулж өгсөн ба шаардлагатай үед ажиллуулна. Анжигасын амны байрлал нь энгэр дагуу байрлалтай бөгөөд тогтмол сэвэлзсэн салхитай байдаг онцлог нь сэргээгдэх эрчим хүч ашиглах таатай нөхцөл байдлыг бүрдүүлж байгаа учраас Төслийн хүрээнд хэрэглэгдэх ахуйн хэрэглээний эрчим хүчийг нарны болон салхины сэргээгдэх эрчим хүч ашиглан шийдвэрлэнэ. Харин тус баазын байрлал нь эрчим хүчний хувьд нэгдсэн сүлжээнд холбогдоогүй байдаг ба төслийн хүрээнд, шаардагдах өндөр чадлын эрчим хүчний хэрэгцээгээ дизель генератор ашиглан хангаж байна.

1.7.2. Цэвэр усны хэрэглээ: Жуулчны бааз байршиж буй газар нь налуу байрлалтай учраас үйлчилгээний байгууламжийг сантехникийн холболтод холбох боломжтой юм. Өөрөөр хэлбэл бааз байгуулах газрын гадаргын дээд талд усан санг, гадаргын доод талд бохир ус цуглуулах савыг тус тус суурилуулж Хөвсгөл нуураас насосоор усан санд ус татаж тэндээс байгууламжуудад түгээх, хэрэглэгдсэн хаягдал бохир усаа цуглуулах битүүмжилсэн саванд цуглуулдаг.

Агарта резортод одоогийн байдлаар “Урал” маркын 3ш машин 2020 онд Агарта резортоос шингэн бохирыг Ханх сумруу тээвэрлэж байсан ба 2021 оноос эхлэн Хатгал Цахим ОНӨААТҮГ-тэй хамтран ажиллах гэрээтэй Хатгал тосгонруу тээвэрлэж байсан.

2022 оноос Герман улсын GRAF брэндийн бохир ус цэвэршүүлэх байгууламжын бүтээн байгуулалтын ажлыг гүйцэтгэж ашиглалтад оруулаад байгаа бөгөөд бохир усыг Монгол улсын MNS 4943 : 2015 Хүрээлэн буй орчинд нийлүүлэх бохир усны стандартын шаардлагад нийцүүлэн цэвэршүүлж байна. Байгалийн усыг зохистой, хэмнэлттэй ашиглах зарчмыг хэрэгжүүлж, аялал жуулчлалын баазын бүх угаалтуур, шүршүүр, гоожуурт автомат мэдрэгчтэй тоног төхөөрөмжийг суурилуулж байнгын ажиллагаатай байлгаж байна. Ахуйн хэрэглээнээс ялгарсан бохир усыг дахин цэвэршүүлж ариун цэврийн угаалга, жорлон, зүлэг услах зэрэгт дахин ашиглана.

2. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.

Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь улирлын онцлогоос ихээхэн хамааралтай бөгөөд ТХГН болон байгалийн үзэсгэлэнт газрыг түшиглэн явагддаг тул байгаль орчинд тодорхой хэмжээний сөрөг нөлөө үзүүлдэг. Энэхүү аялал жуулчлалын төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг 2014 онд анх хийлгэсэн ба 2021 онд “Ашид ананд” ХХК-аар нэмэлт тодотгол хийлгэж үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Эко жуулчны бааз байгуулах төслөөс байгаль орчны төлөв байдал, орон нутгийн нийгэм эдийн засагт нөлөөлж болох нөлөөллүүдийн хэлбэр, түүний эрчимшил зэргийг магадлан жагсааж, болзошгүй нөлөөллийг тодрууллаа.

Хүснэгт 1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Байгаль орчны үзүүлэлт	шууд	шууд бус	өөрөө зохицуулагдах	богино хугацааны	урт хугацааны	буцаж нөлөөлөх	буцалтгүй нөлөөлөх	хүчтэй	дунд зэрэг	бага зэрэг
1. Байгалийн төрөл зүйлийн өөрчлөлт										
Газрын доорх урсацын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Газрын доорх усны чанарын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Ургамлын бүтцийн өөрчлөлт	х				х		х		х	
Хөрсний элэгдэл, эвдрэл	х				х		х			х
Геологийн тогтоцын өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
Зэрлэг амьтдын орон зайн өөрчлөлт	х				х		х		х	
Уур амьсгалын (бичил) өөрчлөлт	Нөлөөлөл байхгүй									
2. Байгалийн нөөц, ашиглалт										
Газрын гадаргын нөөц баялаг	х				х		х			х
Бэлчээрийн байдал	х				х		х		х	
Эрдэс түүхий эдийн нөөц	Нөлөөлөл байхгүй									

Эрчим хүчний нөөц	Нөлөөлөл байхгүй									
3. Байгаль, орчны өөрчлөлт										
Ундны усны чанар, хэмжээ	Нөлөөлөл байхгүй									
Урсгал усны хэрэгцээ	Нөлөөлөл байхгүй									
Агаарын бохирдол	Нөлөөлөл байхгүй									
Хөрсний эвдрэл, бохирдол	x				x		x		x	
Хорт бодис усаар дамжин хүн, амьтанд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Дуу чимээ, шуугианы нөлөө	Нөлөөлөл байхгүй									
4. Байгалийн өнгө төрх, түүх соёлын дурсгалт зүйл										
Байгалийн үзэсгэлэнт өнгө төрх өөрчлөгдөх	Нөлөөлөл байхгүй									
Ландшафтын хэлбэр, өнгө өөрчлөгдөх	Нөлөөлөл байхгүй									
Тусгай хамгаалалттай газар нутагт нөлөөлөх	x				x					x
Түүх соёлын дурсгалт зүйлд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Археологи, палентологийн олдворт нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
5. Нийгэмд үзүүлэх нөлөө										
Дэд бүтцийн хөгжилд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		x		x		x				x
Хүн амын орлого өөрчлөгдөж нэмэгдэх	x			x			x			x
Хүн амын эрүүл мэндэд нөлөөлөх	Нөлөөлөл байхгүй									
6. Эдийн засаг										
Татварын орлого өөрчлөгдөх	x				x	x			x	

Татварын орлого өөрчлөгдөх	x				x	x			x	
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	x				x					x
Ажлын байр нэмэгдэх	x				x		x			x
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	x				x		x		x	
6. Бусад нөлөөлөл										
Шороон зам харилцаа, авто машины хөдөлгөөний нөлөөллөөс хөрс эвдрэх	x				x		x		x	
Ахуйн бохир уснаас хөрс бохирдох	x				x		x		x	
Хог хаягдлаар хөрс, ус бохирдох	x				x		x		x	
Шатахуун, түлшний алдагдлаар хөрс, ус бохирдох	x				x		x		x	
Дүн	19	1	0	2	16	3	12	0	11	7

3. БАЙГАЛЬ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилтын хүрээнд төслийн үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлэх аливаа сөрөг нөлөөллөөс зайлсхийх, урьдчилан сэргийлж ажиллаа.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан аялал жуулчлалын баазын үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээнд шаардагдах зардлыг төсөвлөж ажилласан.

3.1. Байгаль орчныг хамгаалах, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардлын хураангуй

Хүснэгт 2. БОМТ зардлын хураангуй

№	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө	Нийт зардал (төг)
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	4,200,000
2	Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө	Биологийн нөхөн сэргээлтийн төлөвлөгөө
3		Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
4		Удирдлага зохион байгуулалтын авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
Нийт зардал		8,285,000

4. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хөвсгөл нуурын энгийн хамгаалалтын бүс хог хаягдлаар бохирдох, үйл ажиллагаанд өртөх, ахуйн хатуу, шингэн хог хаягдлыг зүй зохистой зайлуулаагүйн улмаас гадаргын усыг бохирдуулж болзошгүй байдал, техник, хүний хөдөлгөөний улмаас ургамал, хөрс доройтох зэрэг сөрөг нөлөөллийг бууруулах ажил арга хэмжээг авч ажиллаа.

2025 оны “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-д усны нөөц бохирдох, хомсдохоос урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах дараах ажил, арга хэмжээ төлөвлөж хэрэгжилтийг ханган ажилласан.

Хүснэгт 3. Сөрөг нөлөөлөл бууруулах ажлын биелэлт

д/д	Гол ба болзошгүй сөрөг нөлөөллүүд.	Урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах арга хэмжээ	Хамрах хүрээ	Биелэлт
1.Агаар				
1	Машин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тоос, шороо босох -Зорчигчдын ирж, буцах автозамын дагуу босох шороо, тоос, бохирдол зэрэг сөрөг нөлөө үүсэх	-Машин, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний тоос, шороо босохоос урьдчилан сэргийлэх	Жуулчны баазын талбай, эргэн тойрны бүс.	-Жуулчны баазын план зураг, ерөнхий төлөвлөгөөний зурагт зам талбайн зураг тодорхой тусгаж өгсөн байдаг. -Хавар, намрын хуурайшилттай үед чийгшүүлэх усалгаа хийдэг. -Амралтын газар нь чийглэг уур амьсгалтай, бороо, цас их ордог учраас тоос харьцангуй багатай. Мөн бид амрагчдаа усан замаар татан авдаг үйлчилгээний 1-2 машин тодорхой маршрутаар зорчдог тул тоос шороо бага үүсдэг.
2		- Машин, техник, дизель станцын хөдөлгүүрээс ялгарах хорт хийг бууруулах	Жуулчны баазын талбай, эргэн тойрны бүс.	-Үйлчилгээнд буюу ахуйн бохирын машин, хогны машины засвар үйлчилгээг графикт хугацаанд хийж хөдөлгүүрээс ялгаруулах хорт хийг бууруулдаг. -Мөн бид 4 ш жижиг эко цахилгаан машиныг үйл ажиллагаандаа ашиглаж байгаа нь машин техникээс агаар бохирдуулах нөлөөллийг бууруулж байгаа байгальд ээлтэй шийдэл юм. Зураг 2.
2. Газар, хөрсний эвдрэл, доройтлын нөхөн сэргээлт, бохирдолоос хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ				
3	Барилга, байгууламж, шинэ объект барих, амрагч, аялагч, ажиллагсдын хөдөлгөөнөөс амралтын ашиглалтын талбайд хөрс, ой,	- Жуулчны бааз, амралтын газрын орчимд ногоон байгууламж барих, моджуулах, зүлэгжүүлэх	Жуулчны баазын талбай, эргэн тойрны бүс.	-Нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд алаг цоохор ахиж зүлэг ургахгүй болсон 2 га газарт ахин шинэчлэн зүлэгжүүлээ. Өмнөх жилүүдийн тарьсан зүлэгжсэн талбайг услаж тордох ажил байнга хийгдэж байна. Ингэснээр ногоон байгууламжын хувь өссөн. Зураг 1.

	ургамалд нөлөөлөх сөрөг			<p>- Амрагч аялагчдыг тогтсон зам маршрутаар аялуудаг ба үүнд зохион байгуулагч нар хяналт тавьж, санамж анхааруулга өгдөг.</p> <p>-Жуулчны баазын бүтээн байгуулалтын ажил дууссан учраас 2025 онд барилга байгууламж шинээр баригдаагүй бөгөөд өмнөх жилүүдийн халцарч доройтсон газрыг ургамалжуулах ажил хийгдсэн.</p>
4	Аялагч, зорчигч, жуулчны баазын машин, техник , завь, шатахууны агуулах сав, дизель станцаас бензин, шатахуун, тос, тосолгооны материал хөрсөнд нэвчих, усанд орж бохирдуулж болзошгүй	-Машины зогсоол, машин угаах, засварлах газар, шатахууны агуулах сав, дизель станц, завины зогсоол зэрэг бензин, дизелийн түлш, тос, тосолгооны материал асгарч, гоожих зэргээр хөрсөнд нэвчих, ус бохирдуулахаас хамгаалах ажлыг зохион байгуулах	ШТМ-ын агуулах, машин техник, тээврийн хэрэгслүүд	<p>-Хог хаягдлын түр цэг, машины зогсоол зэрэг газраас борооны усаар дамжин нуурын усыг бохирдуулж болзошгүй арга хэмжээ авч, хог хаягдлыг тогтмол ачиж Хатгал сумын нэгдсэн цэгт хүргүүлэх, бензин тос асгаралтаас сэргийлж ажиллаа.</p> <p>-Машины зогсоол, засвар үйлчилгээ, шатахууны агуулах, дизель станц, завь зогсоолд бензин, дизелийн түлш, тос, тосолгооны материалын асгаралт, гоожилт гаргахгүй байх, хөрс эвдэх, хөрс, усны бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор 2 хэсэг нийт 500 м2 цементэн хучилттай зогсоол, эко хавтан зам, үл нэвчүүлэх геомембран хальс дэвссэн талбайг байгуулан ажиллаж байна.</p>
3. Гадаргын болон газрын доорх усны нөөцийг хамгаалах				
5	Далайн эргээр аялах, зугаалах, усанд шумбах, сэлэх үеийн сөрөг нөлөөлөл	-Далайн усанд сэлэх, шумбах, далайн эргээр аялагчид усанд ямар нэгэн бохирдол оруулахгүй байх сурталчилгаа байнгын харуул хяналт тавих, хяналтын камер байршуулах	-Амралтын газрын баруун эргийн эргэн тойрныг бүрэн хамруулна. Анжигасын голын дагуух байршилд.	<p>-Нуурын эрэг дагуух газрын хог хаягдлыг өдөр тутамд цэвэрлэдэг. Мөн хог хаягдал хаяхгүй байх анхааруулга, санамжийг өгч 24 цагийн хяналтын камер байршуулсан ажиллаж байна.</p> <p>-Амрагчид нуурын усанд орох, сэлэх асуудал бараг гардаггүй. Жуулчны бааз нь усанд орох тохилог орчныг бүрдүүлсэн учир нуурын усыг бохирдуулах сөрөг нөлөө гардаггүй болно.</p>

5. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Баазын бүтээн байгуулалтын ажлын явцад доройтсон газрыг зүлэгжүүлэх, мод тарих ажлуудыг хэрэгжүүлэв.

Энэ хүрээнд нийт 2 га талбайн хөрсийг 40 см гүнтэй хагалж боловсруулж, шимлэг хөрс 20-30 см зузаантайгаар жигд тараах, 10 см зузаан 2000 м3 хар шороогоор хучих бэлтгэл ажлуудыг явуулсан.

Зүлэгжүүлэлтэд улаан ботууль, хиагийг 20 м2 талбайд 1 кг-аар тооцож нийт 1000 кг үр суулгасан. Ургамал тариалсан талбайн усалгаа арчилгааг сайтар хийсний үр дүнд жигд сайн ургасан. Эдгээр ажлын үр дүнд 2 га талбайг ургамалжуулаад байна. Зураг 1,5.

6.ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Аялал жуулчлалын баазын талбай орчимд аливаа түүх, соёлын өв, дурсгалт олдвор тэмдэглэгдээгүй бөгөөд хэрвээ олдвор олдвол Соёлын өвийг хамгаалах хуулийн дагуу арга хэмжээ авах, олдворыг гэмтээхгүйгээр хамгаалалтад авч, холбогдох газарт мэдэгдэх үүднээс ажилчиддаа үүрэг чиглэл өгч ажилладаг.

7. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Хүснэгт 4. Хог хаягдлын төлөвлөгөөний биелэлт

д/д	Төлөвлөсөн ажил, арга хэмжээ	Биелэлт
1	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг өөрийн үйл ажиллагаанд тохируулан боловсруулж батлуулах, хэрэгжүүлж ажиллах.	- “Хог хаягдлын журам” -ыг жуулчны баазын бүсэд мөрдүүлэн ажилладаг. Шинээр ирсэн ажилчид болон амрагчдад тус журмыг танилцуулдаг. -Ханх сумтай Хог хаягдлын гэрээ байгуулан Хөвсгөл аймгийн “Бор согоот” ХХК-тай хамтран Хатгал тосгонд байрлах Ландфиллын байгууламжид ахуйн шингэн болон энгийн хог хаягдлаа ангилан тусгай зориулалтын машинаар нийлүүлж байна.
2	Хогийг ангилах ялгах, цэгийг сайжруулах, байнгын арчилгаа тордолт хийх, талбайн зонхилох салхины доод талд багтаамж сайтай хогийн сав байршуулах, ангилан ялгах тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулах.	-Энгийн болон аюултай хог хаягдлын цэг байгуулж хогийг ангилах ялгах, байнгын арчилгаа тордолт хийж, тэмдэг тэмдэглэгээтэй болгох, ажилчид үйлчлүүлэгчид хог хаягдлаа ил задгай хаяхгүй байхыг анхааруулсан самбар, тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.

3	Талбай болон ажлын байрыг тогтмол цэвэрлэж байх. Ажилчдыг цэвэрлэгээний бодис хэрэглэлээр байнга хангаж байх хэрэгтэй.	-Гаднах орчин , ажлын байр, амрах байрыг өдөр бүр тогтмол цэвэрлэж, шаардлагатай үед ариутгал хийж байна. -Цэвэрлэгээний төрөл бүрийн материалаас гадна, 2025 онд хлорамин 200 кг, жавелин 50 ш зэрэг ариутгалын бодис худалдан авч хэрэглэсэн.
4	Орчны хог хаягдал цэвэрлэх	-Нуурын эрэг дагуу 7 хоног бүр хог цэвэрлэгээ хийж хэвшсэн.
5	Ахуйн шингэн бохирыг стандарт шаардлагад нийцүүлэн цэвэрлэх	-Шингэн бохирын хаягдлын халих, шүүрч хүрээлэн буй орчин, хүний эрүүл мэндэд учрах сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлж Герман улсад үйлдвэрлэсэн цэвэршүүлүүлэх байгууламж суурьлуулсан ба өглөө бүр хариуцсан ажилтан хянаж ажиллахаас гадна орон нутгийн байгаль орчны байгуулагаас мөн үзлэг шинжилгээ хийгддэг болно.

8. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

Төслийн “Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр”-т жуулчны бааз, аялал жуулчлалын газрын үйл ажиллагааны явцад байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг хянах зорилгоор тодорхой цэгүүдээс дээж авч шинжилгээнд хамруулсан.

Хүснэгт 5. Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлт	Хэмжих нэгж	Байршил	Хугацаа, давтамж	Хяналт шинжилгээний ажлын хэмжээ	Нэгж өртөг мян.₮	Нийт зардал мян ₮\жилд	Стандарт, аргачлал
Далайн усны эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Далайн эрэг \4 цэгээс\	8 дугаар сард	Цэг бүрээс 1,5 литр дээж	62.5	500.0	Усан орчны чанарын үзүүлэлт. Ерөнхий шаардлага.MNS 4586:1998
Голын усны эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Далайн эрэг \4 цэгээс\	8 дугаар сард	Цэг бүрээс 1,5 литр дээж	62.5	500.0	
Хөрс Эрүүл ахуйн шаардлага	Тус бүр 1 дээж	Амралтын газрын 4 цэгээс	8 дугаар сард	Цэг бүрээс 2 кг дээж	110.0	880.0	Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ. MNS 5850 : 2008

Агаарын чанарын ерөнхий шаардлага	1 дээж	Орчны цэгээс	8 дугаар сард	Цэг бүрээс 1 дээж	55.0	55.0	Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS4585: 2007
Нийт дүн:						1935.0	

9. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Байгаль орчны хууль, тогтоомжийг баримталж, төлөвлөгөө, гэрээнд тусгагдсан ажлыг гүйцэтгэх удирдлага, зохион байгуулалтын ажил арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаа. Орон нутагт мэдээ тайлан хүргүүлэх ажлууд хийгдсэн. Үүнд:

1. 2025 онд ажиллахдаа Газрын гэрээ, ус ашиглах дүгнэлт, гэрээ, хог хаягдлын гэрээг БОУАӨЯ, Хөвсгөл аймгийн БОГазар, Хөвсгөлийн УТХГ-ын хамгаалалтын захиргаа, Ханх сумын захиргаа зэрэг байгууллагаар хянуулан батлуулж, гэрээ байгуулан ажилласан.

2. Амрагч, аялагчдын ой мод, уул, далайн хөвөөгөөр аялах зам, чиглэл маршрут гарган тогтсон нэг маршрутаар хөтөчтэй аяладаг бөгөөд энэхүү аялалдаа галын хор, эмийн сан анхааруулах мэдэгдэл өгч, зөөврийн эко жорлон авч явдаг.

3. Хууль бусаар ан амьтан агнах, ургамал түүх, гал түймэр алдах, хог хаягдал хаях зэрэг зөрчил гаргахгүй байх талаар амрагч аялагч нар байнга анхааруулга, санамж өгч ажиллаж байна.

4. Галын машин байнга бэлэн байдаг бөгөөд объект тус бүрт 1-5 галын хор эрсдэлд зориулан байрлуулж болзошгүй гал түймрээс сэргийлэн ажилладаг.

5. Ой хээрийн түймэрээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт хичээл орж, төлөвлөгөө боловсруулж, ажилчид болон нутгийн иргэдэд анхааруулга, санамж өгч ажилласан.

10. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ

Ханх сумын захиргаанд шаардлагатай мэдээллийг хүргэх, нутгийн иргэдэд нээлттэй үйл ажиллагаагаа танилцуулж, мэдээлэл түгээж ажиллаж байна.

Байгаль орчныг хамгаалах өдөрлөг, аян зохион байгуулж, олон нийтийг татан оролцуулж мод тарих, хог цэвэрлэх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулж, энэ үеэр 12 иргэнд байгаль орчны талаарх мэдээлэл түгээж, сурталчилгаа хийв.

-----ooOoo-----

Хавсралт зургууд.



Зураг 1,2. Доройтсон, халцарсан газруудыг зүлэгжүүлсэн байдал. Эко цахилгаан машин ашиглаж байна.



Зураг 3, 4. Явган хүний зам, ус цуглуулах суваг



Зураг 5,6. Орчны цэвэрлэгээ хийгдсэн байдал болон анхааруулах тэмдэг.



Зураг 7,8. Байгаль орчны сургалт, сурталчилгааны ажлууд хийгддэг.



Зураг 9, 10. Галын машин, унраагуураар бүтэн хангагдаж болзошгүй гал түймрээс сэргийлэн ажиллаж байна.



Зураг 11. Хог хаягдлыг тогтмол цэвэрлэж байна.

-----ooOoo-----

ХАВСРАЛТ МАТЕРИАЛ

№	Материал	Хуудас
1	Аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ	1
2	УТХГН-т газар ашиглах гэрээ	6
3		
4		
	Нийт	